

ЛЕВ ГУМИЛЁВ

Ж.Болдбаатар.

Монгол улсын их сургууль, Түүхийн судалгааны хүрээлэн

jigid_boldbaatar@yahoo.com

Өгүүллйн товч утга: Оросын нэрт түүхч, газар зүйн эрдэмтэн Л.Н.Гумилевийн амьдралын тухай товч мэдэгдэхүүн өгөх болно.

Түлхүүр үг: Баривчилгаа, тэрсүү үзэлтэн, Турк, Бетецк, Ленинград, хаант улс, этнос, этногенец

Лев Николаевич Гумилев 1912 онд Оросын Царское село хотод нэрт хоёр яруу найрагч Николай Степанович Гумилев, Анна Андрьевна Ахматова нарын гэр бүлд хүй цөглөж, хүмүүн заяа залгажээ. Тэрбээр эмэг эх Анна Ивановна Гумилевийн гар дээр голчлон өсч, эхлээд хөдөө тосгонд, дараа нь Бетецк хотноо амьдарч, тэнд дунд сургууль төгссөн байна.

Л.Гумилев Ленинградад ирмэгц түүхийн шинжлэх ухааныг сонирхон оролдож, 1930 онд Герцений институтэд элсэх гэсэн боловч тайж угсаатайн улмаас хасагджээ. Тэгээд Геологи хайгуулын институтэд ажилд орж, геологийн ухаан судалсан байна. Тэрбээр Сибирь, Байгалийн орчмоор хайгуул хийж, улмаар Тажикстан, Крымд ажиллажээ.

Эцэг нь цөлөгдөж байсан, тайж угсаатай гэх мэтээр цааргалж байгаад Л.Гумилевийг Ленинградын их сургуулийн Түүхийн факультетэд элсүүлсэн байна. Нэг жил суралцаж байтал хойт эцэг Н.Н.Путин нь баривчлагдахад түүнийг ч бас хамсаатан хэмээн үзжээ. Левийг их сургуулиас хөөсөн байна. Гэхдээ их сургуулийн ректор Лазуркин II дамжааны шалгалт өгөхийг зөвшөөрч, III курст орсон байна.

Тэрбээр 38 насандаа эцэг Л.С.Гумилевийн “хэрэг”-ийн улмаас дахин баривчлагджээ. Тэрбээр хэдэн жилийг хоригдлын амьдралаар өнгөрөөж байгаад, 1943 онд дайны фронтод явж, эх орныхоо төлөө баатарлагаар тулалджээ.

Фронтоос буцаж ирэхэд Ленинградын их сургуулийн Түүхийн факультетийн декан Мавродин Левийг талархалтай хүлээн авч, IV, V дамжааны шалгалтыг өгүүлснээр их сургууль дүүргэсэн байна. Улмаар тэрбээр тус сургуулийн Дорно дахины институтийн аспирантурт шалгалт өгч, профессор Артамоновын удирдсан экспедицид оролцож шинжилгээний ажлаар явсан байна.

Экспедицээс буцаж ирэхэд Гумилевийн ээж Анна Ахматовагийн шүлгүүд нь Жданов, И.В.Сталин нарт таалагдаагүй учир түүнийг ЗХУ-аас гарч явахыг шаардсан байна. Ингэж түүний амьдралд хар өдрүүд дахин үргэлжилжээ. Л.Гумилевийг аспирантурт элсүүлсэнгүй, цалин, хангамжгүй ч үгүй болов. Ашгүй түүнийг Балины галзуугийн больницын номын санчаар ажилд авсан байна. Тэнд хагас жил ажиллаад, Их сургуулийн захирал Вознесенскийд хандахад эрдмийн зэрэг хамгаалах зөвшөөрөл өгчээ. Тэрбээр “Туркийн анхны хаант улсын улс төрийн нэн тодорхой түүх” сэдвээр түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг горилсон зохиол бичжээ. Гэтэл энэ чиглэлийн гол мэргэжилтэн, Киргизийн шинжлэх шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн А.Н.Берштам эрдмийн зэрэг горилсон зохиолыг нь 16 зүйлээр эсэргүүцсэн шүүмж өгчээ. Тэр бүхнээс марксизмыг хангалттай эзэмшээгүй, дорно дахины гадаад хэл мэдэхгүй гэсэн үндэслэл гол нь байв. Уг нь тэрбээр зохиолдоо перс, турк хэлнээс баримт сэлт ашигласан аж. Гэхдээ Эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн 16 гишүүнээс 15 нь санал өгсөн учир түүнд түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг олгохоор болсон байна. Чингээд ЗХУ-ын угсаатны зүйн музейд эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллажээ. Эрдмийн зэрэг, цол олгох дээд комиссоос дэд эрдэмтний дипломыг нь өгөхгүй хойшлуулсаар байв. Гэтэл Л.Гумилевийг 49 настай байхад нь дахин баривчилж, марксизм хангалттай судлаагүй, эцэг, эх нь батгүй этгээд гэх мэт аар саар зүйл асууж байцаасаар Онцгой зөвлөлгөөнд өөрийг нь оролцуулалгүйгээр 10 жилийн ял оноожээ.

1956 оны ЗХУКН-ын ХХ их хурлын дараа байгуулагдсан комисс Л.Гумилевийн хэргийг нягтлан үзээд, түүнийг бүрэн цагаатгаж, суллажээ. Үүнд профессор Артамонов, Окладников, академич Струве, Конрад нар эерэг сайн тодорхойлолт гаргаж өгсөн нь тус болжээ.

Л.Гумилев түмэн бэрхшээлтэй тулгарч байж Ленинградын Эрмитажид ажилд орж, нийтийн байрны 12 кв м давчуу өрөөнд амьдрах болсон байна. Тэрбээр маш шаргуу ажиллаж, 1960 онд “Хүннү” хэмээх бүтээлээ туурвин хэвлүүлжээ. Түүнчлэн хэд хэдэн өгүүлэл нийтлүүлсэн байна. Улмаар диссертаци бичиж, 1961 оны XI сард хамгаалжээ. Москвагийн дорно дахины институт эхлээд түүний бүтээлд таагүй хандаж байснаа сүүлд нь зөвшөөрчээ. Дараа нь Их сургуулийн захирал Александров түүнийг эрдэм шинжилгээний ахлах ажилтнаар авчээ. Харин түүхийн факультетэд биш, Газарзүй-эдийн засгийн институтэд ажиллуулсан байна. Тэрбээр: Энэ институтэд ажилласан үеэ хамгийн жаргалтай үе байсан, учир нь түүхчид, дорно дахины судлаачид шиг надаар оролдож, гомдоогоогүй тайван ажиллах боломж олгосон гэж өөрийнхөө гараар бичсэн намтартаа тэмдэглэжээ. Л.Гумилев “Эртний Түрэгүүд” номоо бичиж, Хятадын газар нутгийн өнгөлзлөгт няцаалт өгчээ. Хятадууд түүнийг урвагч хэмээн зэмлэсэн боловч, Монгол, Дундад Ази дахь газар нутгийн өнгөлзлөгөөсөө бага боловч татгалзжээ. Дараа нь тэрбээр “Санаанаасаа зохиосон хаант улс” (Поиски вымышленного царства) зохиолоо туурвиж, түүнийхээ эхэнд “Ах дүү Монголын ард түмэнд зориулав” хэмээн бичээд, IX-XIII зууны Төв Азийн улс түмний амьдралын тухай сэтгэл хөдлөм, шунан дурламаар маш тодорхой өгүүлжээ. Түүнчлэн манай өнгөрсөн түүхийг Киевийн Русь ба Москвад Оросын шинэ улс байгуулагдсан хэмээх хоёр үе болгон задлан шинжилсэн байна. Чингээд Чингис хааны ялагдлын үр дүнд хаант улс үүссэн юм бол дэлхий дахины түүхэн явц хэрхэн өөрчлөгдсөн юм бэ? гэгээн Ионнын хаант улс үнэхээр бодит зүйл байсан гэж үү гэсэн асуулт тавьсан байна. Ийнхүү Ионнын хаант улсын тухай үзэл санаа хуурамч, бодлогогүй зүйл болохыг няцаажээ. Энэ зохиолыг академич Б.А.Рыбаков “Түүхийн асуудал” сэтгүүлд 42 баримт гарган шүүмжилжээ. Л.Гумилев мөн хариу няцаалт өгсөн билээ.

Дараа нь Л.Гумилев Монголын үе хүртлэх түүхийн цуврал болох “Хятад дахь Хүннү” зохиолоо бичжээ. Тэрбээр Газар зүйн институтэд нийгмийн идэвхтэй үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ угсаатны зүйн талаар их зүйл хийсэн байна. Угсаатны зүйн асуудал - “этнос”-ын асуудлаар 30 гаруй өгүүлж бичжээ.

Чингээд “Этногенез, дэлхийн био орчин” хэмээх бүтээлээ туурвижээ. Зохиогч энэхүү бүтээлдээ угсаатан судлал чухал болохыг үндэслэж, этногенезийн (угсаатны үүслийн) талаарх үзлээ нотолгоогүйгээр дурдаж, зохиолынхоо бусад хэсэгт зөрчлийн ээдрээтэй зам руу уншигчдыг хөтлөхөд зориулсан байна. Л.Гумилев: “Этнос-Дэлхийн биосферийн бүтцэд үлэмж онцгой үүрэгтэй бөгөөд биосфер, социосфер (нийгмийн хүрээ) зааг дээрх үзэгдэл гэдгийг урьдчилан хэлье. Энэ үзэл санаа маань тунхаглал мэт боловч юуны тулд энэ номыг бичив, зөвхөн тодорхойлолт өгөх гэж эрмэлзэж бичээгүй, өөрийн хүрсэн бүх замыг харуулах гэж, шинжлэх ухааны таамаглалын өмнө тавигдсан бүх шаардлагыг хангаж байгаад итгэдгээ үндэслэх гэж бичив. Бид үүнийхээ дараа нотолгооныхоо системд шилжиж болох юм” гэж зохиолынхоо эхэнд цохин тэмдэглэжээ. Мөн зохиолдоо эрчимт хүчний онолын шинэ таамаглал дэвшүүлсэн юм. Тэрбээр “пассионарность” хэмээх ойлголтоор хүн төрөлхтөний эрчимлэг байдлыг тодорхойлсон. Сансараас ойх туяаны тусгалаар эрчимлэг байдал бий болдог. “Пассионарность” нь эрчим хүч бөгөөд инстинктийн эргэх вектор болон хэт ачааллын чадварыг тодорхойлдог амьд бодосын биохимийн энергийн илүүдэл бөгөөд тэрхүү эрчмийн чанарыг шингээж чадсан ард түмэн хүн төрөлхтөний хөгжлийг хөтөлдөг гэж үзсэн байна.

1980-аад оны сүүлч үеэс Л.Гумилевийн судалгааны өвөрмөц арга, хандлага, сонин содон бүтээл, нээлтүүд нь эрдэмтэн судлаачдын анхаарлыг татаж, тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн байна. ОХУ болон хилийн чинадад Л.Н.Гумилевын бүтээл, үзэл санааны өвийг судалж, сонирхох нь илт ихэсчээ. “Мир Л.Н.Гумилева” сангаас

IV. ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

“Санаанаасаа зохиосон хаант улс”, “Этногенез, дэлхийн био орчин”, “Төгсгөл ба шинэ эхлэл”, “Русиэс Орос хүртэл”, “Эртний Төвд”, “Хазарийн нээлт”, “Эртний Русь ба уудам тал нутаг”, (Хоёр боть), “Эртний Түрэгүүд” хоёр боть, “Каспийн эргэн тойрон дахь мянган жил” бүтээлүүдийг нь олон хувь хэвлэн гаргажээ. Өөрийнх нь гараар бичсэн намтар, Сергей Лавровын “Лев Гумилев: судьба и идей” зохиол, Л.М.Гумилевын тухай хамтран зүтгэгчдийн дурсамжууд орсон “Лев Гумилев: судьба и идей” (М.2008) ном, “Тайхамшигт хүмүүсийн амьдрал” цувралаар Валерий Деминий “Лев Гумилев” (М.2008) зохиол нийтлэгджээ.

Лев Гумилёв бол хуучин тогтолцоо, үзэл суртлын дарамт шахалттай үед түүхэн үнэн, ялангуяа Монголын түүхэн үнэнийг зоригтой гарган тавьж байснаараа тэрслүү үзэлтэн гэж хавчин гадуурхагдаж, шорон оронд орж, хэлмэгдэж явсан боловч үнэн үйл хэргээсээ хэзээ ч ухраагүй билгүүн номч, их сэтгэгч эрдэмтэн байсан бүлгээ.

Резюме

В статье рассказывается жизненный путь выдающегося историка и этнолога и географа Льва Николаевича Гумилёва. В этой статье также раскрываются в кратком виде идейные корни и различные аспекты космологических взглядов Л.Н.Гумилёва, основанных на учении о биосфере и ноосфере, евразийской теории и концепции пассионарности.